



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
ГАЗАР**

67123. Мөрөн. Хөвсгөл аймаг.

Утас: 70382216

[www.khovsgol.gov.mn](http://www.khovsgol.gov.mn)

2019. 04.17 № 3/721

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**АГЕНТЛАГ, БАЙГУУЛЛАГЫН ДАРГА  
НАРТ**

“Жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөр” аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн хурлын 2019 оны 3 дугаар сарын 29-ний 37 дугаар тогтоолоор батлагдлаа.

Иймд өөрийн сум, байгууллагын онцлогт тохируулан төлөвлөгөө гарган хэрэгжүүлж ажиллахыг мэдэгдье

Хавсралт.13 хуудастай.

ДАРГА



Х.ГАН-ОЧИР



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
ГАЗАР**

67123, Мөрөн, Хөвсгөл аймаг.

Утас: 70382216

[www.khovsgol.gov.mn](http://www.khovsgol.gov.mn)

2019.04.17 № 3/732

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т


**СУМДЫН ЗАСАГ ДАРГА НАРТ**

“Жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөр” аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн хурлын 2019 оны 3 дугаар сарын 29-ний 37 дугаар тогтоолоор батлагдлаа.

Иймд өөрийн сум, байгууллагын онцлогт тохируулан төлөвлөгөө гарган хэрэгжүүлж ажиллахыг мэдэгдье

Хавсралт. 13 хуудастай.

ДАРГА



Х.ГАН-ОЧИР



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2019 оны 3 сарын 29 өдөр

Дугаар 37

Мөрөн

**Жендэрийн эрх тэгш байдлыг  
хангах дэд хөтөлбөр батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1 дэх заалт Засгийн газрын 2017 оны 129 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөр”-ийг хавсралтаар баталсугай.

2. Хөтөлбөрийг үр дүнтэй зохион байгуулж, шаардагдах төсвийг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, төсөвт тусган батлуулж, ажиллахыг аймгийн Засаг дарга (Л.Ганболд)-д даалгасугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга (Ц.Гончиг), хөтөлбөрийн хэрэгжилт үр дүнг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанд жил бүрийн 4 дүгээр улиралд багтаан танилцуулж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Ж.Ганболд)-д нарт тус тус даалгасугай.


ДАРГА



Л.ТӨМӨРБААТАР

## ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ДЭД ХӨТӨЛБӨР

(2019-2021)



1. Жендэрийн тэгш байдлыг хангах дэд хөтөлбөр боловсруулах үндэслэл, өнөөгийн нөхцөл байдал

Жендэрийн тэгш байдал<sup>1</sup> нь хөгжлийн чухал зорилт бөгөөд эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлж, ядуурлыг бууруулахад ихээхэн хувь нэмэр оруулдаг. Жендэрийн тэгш байдлыг хангах нь эрэгтэй, эмэгтэй хүмүүс нийгмийн бүлгүүдийн аль алиных нь ашиг сонирхолд эергээр нөлөөлдөг бөгөөд нийгмийн хөгжилд төдийгүй ирээдүй хойч үедээ хийж буй хөрөнгө оруулалт юм.

Хөвсгөл аймгийн Жендэрийн тэгш байдлыг хангах дэд хөтөлбөр нь (Цаашид “Дэд хөтөлбөр” гэнэ) Монгол Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ийн 5-р зорилт “Жендэрийн эрх, тэгш байдлыг хангах” зорилт, “Жендэрийн эрх, тэгш байдлыг хангах” тухай хуулийн 19, 20-р заалт, Монгол Улсын засгийн газрын 2017 оны 129 дүгээр тогтоол<sup>2</sup>-оор батлагдсан “Жендэрийн эрх, тэгш байдлыг хангах” үндэсний хөтөлбөр зэргийг үндэслэв.

Дээрх эрх зүйн шийдвэрүүд гарч үндэсний хэмжээнд хэрэгжиж байгаа нь аймаг орон нутагт аймгийн дэд хөтөлбөрийг зайлшгүй хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага байгааг харуулж байна.

Тус дэд хөтөлбөр нь Хөвсгөл аймгийн “Хөгжсөн-Хөвсгөл-2030”, аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны “Хөгжлийн хөтөч-2016-2020” хөтөлбөр түүний хүрээнд хэрэгжиж буй 14 дэд хөтөлбөрүүдийн үзэл санаа, хэрэгжилтийн үйл явц, үр дүнгийн залгамж чанарыг хадгалан үйл ажиллагааг нь жендэрийн мэдрэмжтэйгээр<sup>3</sup> төлөвлөхөд дэмжлэг үзүүлнэ. Өнөөдөр тэгш бус байдал, жендэрийн хэвшмэл ойлголт<sup>4</sup> нь нийгмийн тогтолцоо, хүмүүсийн бодол санаанд бат оршсон хэвээр байгааг бодлогоор засаж залруулах боломж бидэнд байна. Үүний тулд эн тэргүүнд нийгмийн олон талт байдал

<sup>1</sup> -Жендэрийн тэгш байдал гэдэг нь эрэгтэй, эмэгтэй хүмүүс нийгэмдээ болон хувийн амьдралын хүрээндээ эн тэгш үнэлэгдэж, тэгш эрх мэдэл, оролцоотой байж хөгжлийн үйл явцад оролцох болон үр шимийг хүртэх тэгш боломжоор хангагдахыг хэлнэ.

<sup>2</sup> -Хөтөлбөрийн зорилт үйл ажиллагааг эрхэлсэн салбар болон харьяа нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүр эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын болон орон нутгийн төсөвт тусгаж, олон улсын байгууллагын төсөл хөтөлбөрт хамруулах замаар санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

<sup>3</sup> -Жендэрийн мэдрэмж гэж эрэгтэй, эмэгтэй хүмүүс нийгмийн бүлгүүдийн ялгаатай хэрэгцээг, мөн тэдний хөгжлийн үйл явцад оролцох болон үр шимээс нь хүртэхэд хязгаарлалт болж буй хүчин зүйлийг анхаарч тооцох хүсэл, эрмэлзэл мэдлэг чадвар юм.

<sup>4</sup> -Жендэрийн хэвшмэл ойлголт гэдэг нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн тодорхой бүлгүүдийн шинж төрх, ялгаа, гүйцэтгэх үүргийн тухайд нийгэм, соёлын нөлөөгөөр төлөвшин тогтсон хялбаршуулсан ойлголт, төсөөлөл, итгэл үнэмшил юм.

нь соёл, зан заншил, шашин шүтлэг, үндэс угсаа, жөндөр зэрэг хүний олон талт шинж чанар агуулдгийг ойлгон хүлээн зөвшөөрсний үндсэн дээр бодлого төлөвлөлт хийхийн тулд эмэгтэй, эрэгтэй хүмүүс, охид, хөвгүүд, нийгмийн бүлгүүдийн ялгаатай хэрэгцээнд суурилсан жөндөрийн стратегийг орон нутаг өөрийн онцлогт нийцүүлэн боловсруулж, түүнийгээ батлан хэрэгжүүлэх нэн шаардлага байгаа юм.

Хөтөлбөрийг боловсруулахад аймгийн Засаг даргын 2017 оны 67 дугаар захирамжаар байгуулагдсан “Жөндөрийн эрх, тэгш байдлыг хангах” салбар хороо, Жөндөрийн үндэсний хорооноос зохион байгуулсан сургалтанд хамрагдсан төрийн албан хаагчид, Хүний Эрхийн Үндэсний комиссоос зохион байгуулсан сургалтанд хамрагдсан сургагч багш нар үүрэгтэй оролцож, иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл, салбаруудын төлөөллийг оролцуулсан гурван удаагийн хэлэлцүүлгийн үр дүнг тусгасан болно.

Манай аймгийн хэмжээнд 2018 оны жилийн эцсийн байдлаар 134.133 хүн амтай болж 2017 оныхоос 0,98 хувь буюу 1987 хүнээр өссөн байна. Үүнээс 67.580 нь буюу 50,3% нь эмэгтэй байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүн 5616 байгаа бөгөөд үүнээс 2494 нь буюу 44.4% нь эмэгтэй байна. Эрх толгойлсон эмэгтэй 5041 байгаа бөгөөд 2927 нь 18 хүртэлх насны хүүхэдтэй өрх толгойлсон эхчүүд байна. Жөндөрийн хөгжлийн индекс 2016 оны байдлаар 1.026 байсан бол 2017 оны байдлаар 1.032 болсон үзүүлэлттэй байна.

2018 оны байдлаар нас баралт нийт 847 байгаагаас 354 нь буюу 41,7 % нь эмэгтэйчүүд, 58.3% нь эрэгтэйчүүд байна. Нийт нас баралтын дийлэнх хувь нь зүрх судасны өвчлөл, хорт хавдар эзэлж байна. Харин хорт хавдраар шинээр өвчлөгчид 216 байгаагаас Эрэгтэй-114, Эмэгтэй-102, нас барагсад нийт-159 байгаагаас эрэгтэй-96, Эмэгтэй-63 байгааг анхаарч үзэх нь чухал байна.

Хүн амын дундаж наслалт 66.71 байгаа бөгөөд эмэгтэйчүүд 71.6, эрэгтэйчүүд 63,5 байна. Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дундаж наслалт-8.1 пунктээр зөрүүтэй байгаа юм.

Дээрх эрүүл мэндийн үзүүлэлтүүдээс харахад эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн өвчлөлийн байдал, нас баралт, дундаж наслалтын харьцаа харьцангуй өөр өөр буюу эрэгтэйчүүдийн өвчлөл эмэгтэйчүүдийнхээс өндөр, мөн эрэгтэйчүүдийн дундаж наслалт эмэгтэйчүүдийнхээс доогуур үзүүлэлттэй байгаа нь эрэгтэйчүүдийн амьдралын хэв маяг, хооллолт, эрүүл мэнддээ анхаарах хандлага эмэгтэйчүүдийнхээс харьцангуй сул байгааг харуулж байна.

Гэмт хэргийн улмаас 722 иргэн хохирсон бөгөөд үүний 260 нь эмэгтэй, гэмт хэрэгт холбогдсон 500 иргэний 54 нь эмэгтэй байна.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчдийн 90% нь эрэгтэйчүүд байгаа нь жөндөрт суурилсан хүчирхийлэл<sup>5</sup> тэр дундаа гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх ажлыг өргөн хүрээнд авч үзэх гэр бүлийн боловсрол олгох, нийгмийн ухамсрыг төлөвшүүлэх чиглэлээр анхааран ажиллах шаардлага тулгарч байна. Орон нутгийн түвшинд жөндөрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх ажлыг эрчимжүүлэхийн тулд байгууллагууд бие биенээ дэмжсэн цогц зохицуулалт бий болгох, харилцан туршлага солилцох замаар хүний нөөцийг чадавхижуулах хэрэгцээ байсаар байна.

<sup>5</sup> -Жөндөрт суурилсан хүчирхийлэл гэдэг нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн гэр бүл, нийгэм, улс төрийн хүрээн дэх эрх мэдлийн тэгш бус харьцаанаас үүдэн гардаг.

Ажиллагчдын сарын дундаж цалинг 2001 оноос 2017 он хүртэлх үзүүлэлтийг харахад 2009 оноос өмнө жилүүдэд эрэгтэйчүүдийн авч буй цалин эмэгтэйчүүдийн авч буй цалингаас харьцангуй өндөр байсан бол сүүлийн 8 жилд эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн үнэлэмж тодорхой хэмжээгээр дээшилсэн үзүүлэлттэй байна. 2017 оны байдлаар аймгийн дүнгээр 605,7 мянга байгаа бөгөөд үүнээс эрэгтэй-602,6 мянга, эмэгтэй-608 мянган төгрөгийн дундаж цалин авч байна.

Нийт тэтгэвэр авагчдын 70,5 хувийг эмэгтэйчүүд, 29,5 хувийг эрэгтэй тэтгэвэр авагчид эзэлж байна.

Энэ нь эрэгтэй хүний дундаж наслалт эмэгтэй хүнээс бага байгаатай холбоотой, нөгөөтэйгүүр эрэгтэй хүмүүс 60 насандаа тэтгэвэрт гардаг, эмэгтэйчүүд 50, 55 насандаа тэтгэвэрт ордог нь нөлөөлж байна.

Эрэгтэй эмэгтэй хүмүүсийн хөдөлмөрийн зах зээл дэх хөдөлмөр эрхлэлтийн байдлыг харахад эрэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин өндөр байгаа бөгөөд ажилгүйдлийн түвшин эмэгтэйчүүдийнхээс харьцангуй бага байна.

Энэ нь эмэгтэйчүүд нийгмийн амьдралд идэвхитэй оролцох, ажил хөдөлмөр эрхэлж орлого олох, баялгийг бүтээх ажилд оролцохоосоо илүү хүүхдээ өсгөж хүмүүжүүлэх, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсээ асрах зэрэг гэрийн буюу хөлсгүй хөдөлмөр эрхэлж байна

1-р ангид элсэгчдийн 53,6% эрэгтэй хүүхэд, 46,4% нь эмэгтэй хүүхэд байна. Бүрэн дунд боловсрол эзэмшээд 12-р анги төгсч буй хүүхдүүдийн 45,2% нь эрэгтэй, 54,4% нь эмэгтэй байна. Ерөнхий боловсрол эзэмшиж буй охид, хөвгүүдийн харьцаа-1,05 байна. Дээд боловсрол эзэмшиж байгаа хүмүүсийн харьцаа 1,44 байна.

Дээрх статистик мэдээллээс харахад 1-р ангид элсэгчдийн хүйсийн харьцаанаас эрэгтэй хүүхэд дийлэнх /53,6%/байгаа боловч 12-р анги төгсөгчдийн тоо урвуу харьцаатай, их дээд боловсрол эзэмшиж буй хүмүүсийн хүйсийн харьцаа 0,44%-р зөрүүтэй байгаа нь эцэг эхчүүдийн эрэгтэй хүүхдүүдийн боловсролд анхаарах хандлага дутмаг, уламжлалт хандлага давамгайлсан, нөгөө талаас эрэгтэй хүүхдүүдэд боловсролыг чухалчлах сэтгэлгээ хандлага дутмаг төлөвшиж байгааг харуулж байна. Хөвсгөл аймаг нь 23 сум 1 тосгон 128 багтай. Өнөөгийн байдлаар аймгийн ИТХ-ын 41 төлөөлөгчийн 17% нь эмэгтэй төлөөлөгч, сумдын 517 төлөөлөгчийн 131 буюу 25.3% нь, эмэгтэй төлөөлөгч, сумдын ИТХ-ын 23 даргын 17.3% нь эмэгтэй дарга, аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтэс албадын дарга нарын 37.5%, эмэгтэйчүүд байна.

Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо харьцангуй бага хувьтай байгаа бөгөөд гүйцэтгэх албан тушаалд дийлэнх хувийг эзэлж байна.

Дээрх статистик мэдээлэллүүдээс үзэхэд аймгийн хөгжлийн бодлого, төлөвлөлт, үйл ажиллагаа, хяналт үнэлгээнд жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг нэвтрүүлэх, орон нутгийн жендэрийн тэгш байдлыг хангах тогтолцооны чадавхийг бүрдүүлэх, түншлэл, хамтын ажиллагааг хөгжүүлэх, жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааг эрчимжүүлэх, эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг сайжруулах, хүүхдүүдийн боловсрол эзэмшиж буй харьцааг тэнцвэржүүлэх, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх зэрэгт бодлогын дэмжлэг, өөрчлөлт оруулах хэрэгцээ шаардлага тавигдаж байна.

Хэдийгээр жендэрийн эрх тэгш байдлыг хангах эрх зүйн орчин боловсронгуй болж, улс төр, эдийн засаг, нийгэм, соёл, гэр бүлийн хүрээнд жендэрийн тэгш байдлыг хангах чиглэлээр ахиц, дэвшил гарч байгаа боловч хууль хэрэгжүүлэх тогтолцоог бэхжүүлэх, санхүүжилтийг хүрэлцээтэй хуваарилах, хүний нөөцийг чадавхжуулах зэрэг нэн тэргүүнд шийдвэрлэх асуудал байсаар байна.

Аймгийн хэмжээнд жендэрийн эрх тэгш байдлыг хангахад жендэрийн асуудлаарх мэдлэг, ойлголт дутмаг байгааг харгалзан жендэрийн бодлоготой болох шаардлагатай хэмээн үзэж аймгийн жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөрийг Монгол Улсын Жендэрийн эрх тэгш байдлын хангах тухай хууль, үндэсний хөтөлбөр, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилт, Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журамтай уялдуулан боловсруулсан.

## 1. БАРИМТЛАХ ЗАРЧИМ, ХУГАЦАА

Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд баримтлах зарчим:

1. Орон нутгийн онцлог хэрэгцээ шаардлагад нийцсэн хөгжлийн болон салбарын урт хугацааны бодлогуудыг дэмжих, аймгийн хөгжлийн цогц бодлого, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, үндсэн чиглэл зэрэг бодлогын баримт бичгүүдтэй уялдах

2. Эрэгтэй, эмэгтэй хүмүүс хамтран ажиллах замаар жендэрийн тэгш байдлыг хангах нийгмийн зөвшил, түншлэлийг эрхэмлэх

3. Жендэрийн статистик мэдээллийг бүрдүүлж жендэрийн тэгш байдлын талаарх үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах

4. Жендэрийн тэгш байдлыг хангахад чиглэсэн бүхий л сайн туршлага, санаачлагыг урамшуулан дэмжих

Хугацаа:

Дэд хөтөлбөрийг “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр”-тэй уялдуулан 2021 оныг дуустал хэрэгжүүлнэ.

## 2. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО, ТЭРГҮҮЛЭХ ЗОРИЛТ, ХҮРЭХ ҮР ДҮН, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

1. ЗОРИЛГО: Бүх нийтэд жендэрийн боловсрол олгох, орон нутагт жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлтийг нэмэгдүүлэх, жендэрийн эрх тэгш байдлыг хангах орон нутгийн чадавхийг бэхжүүлж, “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангахад энэхүү дэд хөтөлбөрийн зорилго оршино.

2. Бодлогын зорилт, хүрэх үр дүн, үйл ажиллагааны чиглэл

Орон нутгийн жендэрийн бодлогын зорилгыг хангахын тулд дараах зорилтуудыг дэвшүүлнэ. Үүнд:

1. Жендэрийн тэгш байдлыг хангах орон нутгийн тогтолцоог хөгжүүлж, жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлт хийх чадавхийг бэхжүүлэх

2. Эрэгтэй, эмэгтэй хүний гэр бүл, нийгэмд гүйцэтгэх үүрэг, бүх нийтийн жендэрийн боловсролыг дээшлүүлэх

### 3. Жендэрт суурилсан хүчирхийллийг үл тэвчих хандлагыг төлөвшүүлэх

#### 3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл

3.1. Жендэрийн тэгш байдлыг хангах орон нутгийн тогтолцоог хөгжүүлж, жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлт хийх чадавхийг бэхжүүлэх

Нэгдүгээр зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

3.1.1. Аймаг, сум, багийн удирдах ажилтнууд, орон нутгийн манлайлагчдын жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлт, төсөвлөлтийг орон нутгийн онцлогт нийцүүлэн хийх, хэрэгжүүлэх чадавхийг бэхжүүлэх сургалт зохион байгуулна.

3.1.2. Байгууллага бүрт жендэрийн зөвлөл байгуулж тогтмол үйл ажиллагааг хангах

3.1.3. Жендэрийн статистик мэдээллийн нэгдсэн санг орон нутгийн түвшинд салбар бүрээр бүрдүүлэн бодлого төлөвлөлтөд ашиглах

3.1.4. Жендэрийн тэгш байдлыг хангах ажлыг сум, баг, байгууллагын түвшинд хөхүүлэн дэмжиж, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх

3.1.5. Орон нутагт хүчин төгөлдөр үйлчилж буй тогтоол, шийдвэрт жендэрийн үнэлгээ хийх

3.1.6. Жендэрийн тэгш байдлын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хувийн хэвшил, Төрийн бус байгууллагуудтай үр дүнтэй хамтран ажиллах

Хүрэх үр дүн:

- Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэх, жендэрийн асуудлыг бодлого төлөвлөлт, үйл ажиллагаа, хөтөлбөр, төсөлд тусгах жендэрийн мэдрэмжтэй дүн шинжилгээ хийх чадавхи бүрдэнэ.
- Жендэрийн чиг баримжаатай үр бүтээлтэй ажиллах хүний нөөцийн бодлогыг байгууллагын удирдлага, менежерүүд дэмжсэн байна.
- Хөгжлийн бодлого төлөвлөлт, үйл ажиллагааг эрэгтэй эмэгтэй, нийгмийн бүлгүүдийн хэрэгцээнд суурилснаар нөөц боломж тэгш хуваарилагдаж иргэдэд хүргэх төрийн үйлчилгээ илүү үр ашигтай болно.

3.2. Эрэгтэй, эмэгтэй хүний гэр бүл, нийгэмд гүйцэтгэх үүрэг, бүх нийтийн жендэрийн боловсролыг дээшлүүлэх

Хоёрдугаар зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

3.2.1. Өмч эзэмших, өвлөх шийдвэр гаргахад гэр бүлийн гишүүдийн тэгш оролцоог хангах

3.2.2. Хөдөлмөрийн харилцаанд гарч буй шууд болон шууд бус ялгаварлан гадуурхалтыг илрүүлэх, холбогдох арга хэмжээ авах

3.2.3. Жендэрийн тэгш байдлын талаарх орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх

3.2.4 Жендэрийн хэвшмэл ойлголтыг арилгахад нийгмийн бүлгүүдийн тэгш оролцоог хангахад залуучуудын манлайллыг дэмжих



3.2.5. Жендэрт суурилсан хүчирхийллийн суурь шалтгааныг урлаг спортоор дамжуулан соён гэгээрүүлэх үйл ажиллагааг тогтмол зохион байгуулж хэвших

Хүрэх үр дүн:

- Хөдөлмөрийн харилцаан дахь хүйсийн ялгаварлалыг арилгах дэмжлэг бүрдэнэ.
- Жендэрийн хэвшмэл ойлголтын талаар нийгмийн бүлгүүд тодорхой ойлголттой болж жендэрийн хэвшмэл ойлголтоос татгалзах хандлага бий болно.
- Жендэрийн хэвшмэл ойлголтын эсрэг залуучууд дуу хоолойгоо илэрхийлэх боломж бүрдсэн байна.

3.3. Жендэрт суурилсан хүчирхийллийг үл тэвчих хандлагыг төлөвшүүлэх

Гуравдугаар зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

3.3.1. Шийдвэр гаргагчдад жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоход чиглэсэн хууль тогтоомж бодлого хөтөлбөр үйл ажиллагааг төлөвлөхөд нь шаардлагатай нотолгоо мэдээлэл тогтмол өгч, бодлогод тусгахад нөлөөлөх

3.3.2. Хүчирхийллээс өөрийгөө болон бусдыг хамгаалах, урьдчилан сэргийлэх, хүчирхийллийн талаар мэдээлэх асуудлаар олон нийтийн хандлагыг өөрчлөх үе шаттай сургалт зохион байгуулах

Хүрэх үр дүн:

- Жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх хохирогчийн авулгүй байдлыг хамгаалах үйлчилгээний механизм бий болсон байна.
- Хамтарсан багаар ажиллах НЦҮТ-ийн хамгаалах байрны хүчирхийллийн хохирогчдод үйлчилгээ үзүүлэх чадавхийг дээшлүүлсэн байна.
- Гэр бүлийн гишүүд бие биенээ хүндэтгэх, хүчирхийлэлгүй аж төрөх хандлага төлөвшинө.
- Жендэрт суурилсан хүчирхийлэл, ялангуяа гэр бүлийн хүчирхийлэл түүний үр дагаврын талаар олон нийтийн мэдлэг ойлголт нэмэгдсэн байна.

### 3. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ САНХҮҮЖИЛТ

Дэд хөтөлбөрийн санхүүжилтийг дараах эх үүсвэрүүдээс бүрдүүлнэ.

4.1. Улсын болон орон нутгийн төсвөөс хуваарилсан хөрөнгө

4.2. Олон улсын байгууллага болон төсөл, хөтөлбөрийн санхүүжилт

4.3. Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хандив, тусламж

### 5. ХӨТӨЛБӨРИЙН УДИРДЛАГА, ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАГНАЛ, ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

5.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг аймгийн Жендэрийн салбар хороо удирдлагаар хангаж, хэрэгжилтэд хяналт тавьж, салбар хоорондын хамтын ажиллагааг уялдуулан зохицуулна. Жендэрийн салбар хороо хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, шаардлагатай төсвийг жил бүр боловсруулан батлуулж, хэрэгжүүлэх арга хэмжээ,

төлөвлөгөөний хүрээнд аймаг, сумдын Засаг даргын Тамгын газар, салбар хороог мэргэжил, арга зүй, удирдамжаар ханган хамтран ажиллана.

5.2. Аймгийн Засаг дарга, сумдын Засаг дарга болон байгууллагын дарга нартай байгуулах үр дүнгийн гэрээнд жендэрийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх заалтыг тусган, хэрэгжилтийг Нийгмийн бодлогын хэлтэс, Хяналт шинжилгээ үнэлгээ дотоод аудитын хэлтэс үнэлнэ.

5.3. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээг 2 жил тутам хийж тайлангийн биелэлтийг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралд танилцуулна.

5.4. "Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай" хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.8, 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх заалтын дагуу жил бүр тайланг Жендэрийн үндэсний хороонд хүргүүлнэ.

5.5. Хөтөлбөрийн үр дүнгийн хөндлөнгийн үнэлгээг хөтөлбөр хэрэгжих сүүлийн жилд нэг удаа орон нутгийн иргэний нийгэмлэгийн байгууллагын төлөөллөөр хийлгэж, үнэлгээний үр дүнг Засаг даргын Тамгын газарт танилцуулна.

5.6. Хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан, үнэлгээг албан ёсны цахим хуудас, олон нийтийн сонин, мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд ил тод, нээлттэй мэдээлнэ

**ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ДЭД ХӨТӨЛБӨРИЙГ  
ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Ажил, үйлчилгээ /бүтээгдэхүүн/	Хугацаа	Шаардагдах хөрөнгийн хэмжээ	Хүрэх түвшин/үр дүнгийн үзүүлэлтээр/	Хариуцах хэлтэс, албад
---	--------------------------------	---------	-----------------------------	--------------------------------------	------------------------

			Улсын төсөв	Орон нутгийн төсөв	Бусад эх үүсвэр		
1. Жендэрийн тэгш байдлыг хангах орон нутгийн тогтолцоог хөгжүүлж, жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлт хийх чадавхийг бэхжүүлэх							
1.1	Аймаг, сум, багийн удирдах ажилтнууд, орон нутгийн манлайлагчдын жендэрийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлт орон нутгийн онцлогт нийцүүлэн хийх, хэрэгжүүлэх чадавхийг бэхжүүлэх сургалт зохион байгуулна.	2019-2021		15.0		Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэх, жендэрийн асуудлыг бодлого төлөвлөлт, үйл ажиллагаа хөтөлбөр, төсөлд тусгах жендэрийн мэдрэмжтэй дүн шинжилгээ хийх чадавхи бүрдэнэ.	Аймгийн ИТХ, Жендэрийн салбар хороо, НБХ, Сумдын ЗДТГ
1.2	Байгууллага бүрт жендэрийн зөвлөл байгуулж тогтмол үйл ажиллагааг хангах	2019-2021				Жендэрийн чиг баримжаатай үр бүтээлтэй ажиллах хүний нөөцийн	Жендэрийн салбар хороо, НБХ, сум, агентлаг байгууллагууд

						бодлогыг байгууллагын удирдлага, менежерүүд дэмжсэн байна.	
1.3	Жендэрийн статистик мэдээллийн нэгдсэн санг орон нутгийн түвшинд салбар бүрээр бүрдүүлэн бодлого төлөвлөлтөд ашиглах	2019-2021		2.0		Хөгжлийн бодлого төлөвлөлт үйл ажиллагааг эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хэрэгцээнд суурилснаар нөөц боломж тэгш хуваарилагдаж, иргэдэд үйлчлэх төрийн үйлчилгээ илүү үр дүнтэй болно.	Жендэрийн салбар хороо, НБХ, Статистикийн хэлтэс, Агентлаг байгууллагууд
1.4	Жендэрийн тэгш байдлыг хангах ажлыг сум, байгууллагын түвшинд хөхүүлэн дэмжиж, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, сурталчилах	2020-2021		2.0		Жендэрийн тэгш байдлыг хангах сайн туршлага сум, байгууллагын түвшинд бий болсон байна.	Жендэрийн салбар хороо, Нийгмийн бодлогын хэлтэс, сум, агентлаг байгууллагууд
1.5	Орон нутагт хүчин төгөлдөр үйлчилж буй тогтоол, шийдвэрт жендэрийн үнэлгээ хийх	2019-2021		1.0		Орон нутагт хүчин төгөлдөр үйлчилж буй тогтоол, шийдвэрт жендэрийн үнэлгээ хийгдсэн байна.	Жендэрийн салбар хороо, Хууль эрхзүйн хэлтэс,
1.6	Жендэрийн тэгш байдлын					Орон нутагт жендэрийн	

	чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хувийн хэвшил, Төрийн бус байгууллагуудтай үр дүнтэй хамтран ажиллах	2019-2021		5.0	5.0	тэгш байдлыг хангах бодлогыг дэмжсэн төрийн хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудын хамтын ажиллагаа идэвхижсэн байна.	Жендэрийн салбар хороо, Нийгмийн бодлогын хэлтэс, Төрийн бус байгууллагууд
Зорилтын нийт дүн				25.0	5.0		
2.Эрэгтэй, эмэгтэй хүний гэр бүл, нийгэмд гүйцэтгэх үүрэг, бүх нийтийн жендэрийн боловсролыг дээшлүүлэх							
2.1	Өмч эзэмших, өвлөх шийдвэр гаргахад гэр бүлийн гишүүдийн тэгш оролцоог хангах	2019-2021		0.5		Өмч эзэмших, өвлөх шийдвэр гаргахад гэр бүлийн гишүүдийн тэгш оролцоог хангах алхам хийгдэнэ.	Жендэрийн салбар хороо, Хууль эрх зүйн хэлтэс, Улсын бүртгэлийн хэлтэс, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
2.2	Хөдөлмөрийн харилцаанд гарч буй шууд болон шууд бус ялгаварлан гадуурхалтыг илрүүлэх, холбогдох арга хэмжээ авах	2019-2021		3.0		Хөдөлмөрийн харилцаандахь хүйсийн ялгаварлалыг арилгах дэмжлэг бүрдэнэ.	Жендэрийн салбар хороо, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээнй газар, Мэргэжлийн хяналтын газар

2.3	Жендэрийн тэгш байдлын талаарх орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх	2019-2021		3.0		Хэвлэл мэдээллийн салбарын соён гэгээрүүлэх үйл ажиллагаа хэрэгжинэ.	Жендэрийн салбар хороо, НБХ
2.4	Жендэрийн хэвшмэл ойлголтыг арилгахад нийгмийн бүлгүүдийн тэгш оролцоог хангахад залуучуудын манлайллыг дэмжих	2019-2021		5.0	3.0	Жендэрийн хэвшмэл ойлголтыг арилгахад залуучуудын манлайлал бий болж тогтмолжино.	Жендэрийн салбар хороо, Нийгмийн бодлогын хэлтэс, Төрийн бус байгууллагууд
2.5	Жендэрт суурилсан хүчирхийллийн суурь шалтгааныг урлаг спортоор дамжуулан соён гэгээрүүлэх үйл ажиллагааг тогтмол зохион байгуулж хэвших	2019-2021		10.0	5.0	Жендэрт суурилсан хүчирхийлэл түүний үр дагаврын талаар олон нийтийн мэдлэг ойлголт нэмэгдсэн байна.	Жендэрийн салбар хороо, НБХ, БТСГ, БСУГ, Хөгжимт драмын театр
Зорилтын дүн				21.5	8.0		
3. Жендэрт суурилсан хүчирхийллийг үл тэвчих хандлагыг төлөвшүүлэх							
3.1	Шийдвэр гаргагчдад жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоход чиглэсэн хууль тогтоомж бодлого хөтөлбөр үйл	2019-2021		1.0		Жендэрт суурилсан хүчирхийллийн асуудлаар удирдлагуудад зориулсан нөлөөллийн ажил хийгдэнэ.	Жендэрийн салбар хороо, Нийгмийн бодлогын хэлтэс, Гэр бүл, хүүхэд, залуучуудын

	ажиллагааг төлөвлөхөд нь шаардлагатай нотолгоо мэдээлэл тогтмол өгч, бодлогод тусгахад нөлөөлөх					хөгжлийн газар, Цагдаагийн газар
3.2	Хүчирхийллээс өөрийгөө болон бусдыг хамгаалах, урьдчилан сэргийлэх, хүчирхийллийн талаар мэдээлэх асуудлаар олон нийтийн хандлагыг өөрчлөх үе шаттай сургалт зохион байгуулах	2019-2021	5.0	3.0	Сургалтанд хамрагдсан хүний тоо, хэрэгжилтийн хувь	Жендэрийн салбар хороо, Нийгмийн бодлогын хэлтэс, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Цагдаагийн газар, Орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл
Зорилтын дүн			6.0			
Нийт дүн			52.5	16.0		